

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын ГЭРЧИЛГЭЭ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	16
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20
4.5 Аудит хийсэн төлөвлөгөө гүйцэтгэлийн тайлан	21
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУСЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын яам
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

СОЁЛ УРЛАГИЙН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Э.СОНИНТОГОС ТАНАА

2020.03.13 № 06/854
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Соёл урлагийн их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Соёл урлагийн их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Соёл урлагийн их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Соёл урлагийн их сургууль нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Соёл урлагийн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус сургуулийн захирал Э.Сонинтогос танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн байгууллагын дотоод бодлого журмыг шинэчлэх, дагаж мөрдөх, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 үлдэгдэлтэй үндсэн хөрөнгүүдийг бодит үнэ цэнээр бүртгэх, үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалд бүртгэхгүй байх, бараа материалыг зохих зөвшөөрлийн дагуу зөв ангилан зардалд бүртгэх, төсвийг зориулалтын дагуу зөв ангилан бүртгэх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Соёл урлагийн их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Соёл урлагийн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төлөвлөгөө гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Сургуулийн удирдлага нь санхүүгийн тайлан, төлөвлөгөө гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 1-ээс 2020 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Гроут финанс аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямба, Чанарын хяналтын менежер Р.Амарбаясгалан, Аудитор Г.Нандинцэцэг, Гэрээт аудитор Д.Нар-Од, туслах аудитор Ү.Цэцэгмаа, Б.Очирсүх, Э.Пүрэвсүрэн, Д.Нямдаваа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Соёл урлагийн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 01/116 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Соёл урлагийн их сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Соёл урлагийн мэргэжлээр авьяаслаг бүтээлч, шилдэг уран бүтээлч, мэргэжилтнийг бэлтгэж, төрөөс соёл урлагийн талаар баримтлах бодлогод дэмжлэг үзүүлэхүйц судалгааны ажлыг явуулдаг монгол үндэсний соёл урлагийн гол уурхай болоход оршино” гэж тодорхойлсон.

Соёл урлагийн их сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бакалавр, магистр, докторын сургалт, ахлах сургууль, гүнзгийрүүлсэн болон нарийн мэргэжлийн, бэлтгэл мөн мэргэжил дээшлүүлэх сургалтыг явуулах;
- Соёл урлагийн чиглэлээр улсын хэмжээний, салбарын урт, богино хугацааны хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох, зөвлөгөө өгөх;
- Зорилтот суурь болон хэрэглээний судалгаа хийх, шинэ мэдлэг бүтээж, сургалт судалгааны эргэлтэд оруулах, бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Гэрээт, захиалгат, төлөвлөгөөт сэдэв, асуудлаар судалгаа, уран бүтээл, туршилт зохион бүтээлтийн ажлыг гүйцэтгэж, инновацыг нэвтрүүлэх, гарааны компани, инкубатор, байгуулах үйл ажиллагаа эрхлэх;
- Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн сургалт, судалгааны хөтөлбөр, модулиудыг боловсруулан хэрэгжүүлэх, гадаад харилцаа, улс хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Үндэсний болон олон улсын хэмжээний консорциум, холбоо, нэгдэл, парк, кластерт нэгдэн орох;
- Оюуны өмчийг баталгаажуулах, эзэмших, патент, лицензийн үйл ажиллагаа эрхлэх;
- Зөвлөх үйлчилгээ, уран бүтээл зуучлалын үйлчилгээ эрхлэх;
- СУИС-ийн үйл ажиллагааг сурталчлах, үндэсний болон олон улсын хэмжээний наадам, үзэсгэлэн форум, тэмцээн, соёл урлагийн үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Соёл урлагийн их сургууль нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Acolous 3.0 программ, санхүүгийн тайлангийн нэгтгэлийн Plastic 3.0 программ, цалингийн Payroll 2.0 программыг ашигладаг байна.

Соёл урлагийн их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Соёл урлагийн их сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 16 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийг тус сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 10,680.5 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 106.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлсон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс 1 хувиар тооцож 111.7 сая төгрөгөөр баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 111.7 сая төгрөгөөр тооцсон нь жилийн эцсийн үр дүнгийн тайлангаарх зардлын дүн нэмэгдсэнтэй холбоотой болно.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Соёл урлагийн их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,572.9 сая төгрөгөөр буюу 8.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/ сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,611.8	3,136.0	(1,475.8)
Авлага	1,449.9	1,030.8	(419.1)
Урьдчилгаа	11.6	7.4	(4.2)
Бараа материал	1,359.9	1,426.2	66.3
Үндсэн хөрөнгө	11,827.9	12,087.7	259.9
Нийт хөрөнгө	19,261.0	17,688.1	(1,572.9)
Өр төлбөр	2,044.4	1,923.5	(120.9)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	17,216.6	15,764.6	(1,452.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	19,261.0	17,688.1	(1,572.9)

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Зардлын санхүүжилтийн эх үүсвэрийн төлөвлөгөөний дагуу тайлант оны зардлыг санхүүжүүлснээс мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,475.8 сая төгрөгөөр буурсан байна.

Авлагын дансны үлдэгдэл буурсан нь боловсролын яамнаас тогтмол зардлын 2018 оны авлагын үлдэгдлийн санхүүжилтийг олгохгүй гэсэн шийдвэр гарсантай холбоотой 223.5 сая төгрөгийг авлагаас хасаж өмнөх үеийн үр дүнг бууруулсан нь гол нөлөө үзүүлжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 66.3 сая төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал, ном болон тусгай зориулалтын материалын тайлант жилийн худалдан авалтаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 259.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант жилд дотуур байрны 768.5 сая төгрөгийн өргөтгөлийн барилга баригдаж ашиглалтад орсон болон 167.7 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авсан зэргээс шалтгаалсан байна.

ТӨБЗГ-ын 2019 оны А-5/1238, 207 тоот “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” тогтоолын дагуу нийт 305.3 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассантай холбоотой үндсэн хөрөнгийн дүн буурсан байна.

Биет бус хөрөнгө өссөн нь 23.0 сая төгрөгөөр удирдлага мэдээллийн цогц программ шинээр авсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 120.9 сая төгрөгөөр буурсанд тайлант онд суралцагчдын тоо багассанаас сургалтын төлбөрийн урьдчилж орсон орлогын хүлээн зөвшөөрөлт нөлөөлсөн байна

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2019 онд оюутны дотуур байрны өргөтгөл барьсан ажлын, чанарын барьцаа баталгаа 36.9 сая, сургалтын төлбөрийн урьдчилж орсон орлого 1,747.2 сая төгрөгийн өглөг багтаж байна. Энэ нь нийт өр төлбөрийн 92.8 хувийг эзэлж байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 15,764.6 сая төгрөг болж 1,452.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд орлогын төлөвлөгөө биелээгүй, алдагдалтай ажилласнаас шалтгаалжээ.

2.9. ЗОРИЛТОТ ТҮВШИН, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Дээд боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйл, боловсролын тухай хуулийн 36.12.1-т заасны дагуу сургуулийн удирдах зөвлөл холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсролын байгууллагыг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, дүрмийг батлах, өөрчлөх чиг үүрэгтэй.

Энэ чиг үүргийн хүрээнд СУИС-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор сургуулийн 2019 оны төсвийг баталсан.

Тайлант онд 10,769.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 9,814.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 91.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Орлогын гүйцэтгэл

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын төсвөөс санхүүжилт	346.9	-	346.9	0.0
Тусгай зориулалтын сангийн санхүүжилт	77.4	137.4	(60.0)	177.5
Орон нутгийн төсвөөс-Ахлах сургуулийн санхүүжилт	132.8	126.8	6.0	95.5
Өөрийн үйл ажиллагааны орлого	10,212.5	9,550.3	662.2	93.5
Нийт дүн	10,769.7	9,814.5	955.2	91.1

Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т өөрчлөлт орж Монгол улсын 2019 оны улсын төсвийн тухай хуульд төрийн өмчийн их дээд сургуулиудад олгох тогтмол зардал батлагдаагүйгээс тайлант онд улсын төсвөөс санхүүжихээр төлөвлөсөн 346.9 сая төгрөгийн санхүүжилт хийгдээгүй байна.

Тусгай зориулалтын сангийн санхүүжилт нь боловсролын зээлийн сангаас оюутны замын зардлын санхүүжилтийн 9.5 сая төгрөг, Шинжлэх ухаан технологийн сангийн төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн 127.9 сая төгрөгөөс бүрдсэн, тайлант онд Шинжлэх ухаан технологийн сангийн нэмэлт сонгон шалгаруулалтын үр дүнгээр төслийн санхүүжилтийн орлого төлөвлөгөөнөөс 60.0 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Орон нутгийн төсвийн санхүүжилт буюу ахлах сургуулийн санхүүжилт нь суралцаж буй оюутны тооны гүйцэтгэлээс шалтгаалж 6.0 сая төгрөгөөр тасарсан байна.

Өөрийн үйл ажиллагааны орлого нь 2019 онд Ерөнхий боловсролын сургууль төгсөгчийн тоо эрс цөөн, элсэгчдийн тоо хяналтын тооноос бага байснаас зэргээс сургалтын төлбөрийн орлого 662.2 сая төгрөгөөр тасарсан байна.

Тайлант онд Соёл урлагийн их сургуулийн удирдах зөвлөлөөс 13,460.3 сая төгрөгийг урсгал зардалд, 1,321.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, зарцуулахаар төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр урсгал зардалд 10,336.6 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 988.4 сая төгрөгийг зарцуулан нийт зардлын гүйцэтгэл 76.6 хувьтай байна.

Хүснэгт 3. Зардлын гүйцэтгэл

/сая төгрөг/

Ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
УРСГАЛ ЗАРДАЛ	13,460.3	10,336.6	3,123.7	76.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,825.4	6,406.6	1,418.8	81.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	987.3	805.4	181.9	81.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	346.9	229.4	117.6	66.1
Хангамж, бараа материалын зардал	527.1	380.8	146.4	72.2
Эд хогшил, урсгал засварын зардал	891.6	760.8	130.8	85.3
Томилолт, зочны зардал	522.8	308.3	214.5	59.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	287.5	127.7	159.8	44.4
Бараа үйлчилгээний бусад зардал	1,896.3	1,222.2	674.1	64.5
Бусад урсгал шилжүүлэг	175.5	95.6	79.9	54.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,321.8	988.4	333.4	74.8
Дотоод эх үүсвэрээр	1,321.8	988.4	333.4	74.8
Нийт дүн	14,782.1	11,325.0	3,457.1	76.6

Нийт зардал 11,325.0 сая төгрөг буюу 76.6 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь тайлант онд элсэгч, суралцагчийн тоо багассантай холбоотой байна.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 16 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 8 эрсдэл тодорхойлж нийт 24 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,904.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,794.0 сая төгрөгийн алдааг залруулж, 110.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Суралцагчдын төлсөн сургалтын төлбөрийн илүү төлөлт болох 1,747.2 сая төгрөгийг дансны өглөгийн дансанд бүртгэж байгаа нь Сангийн сайдын 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.63 дугаар заалт “Ажил үйлчилгээг гүйцэтгэж хүлээлгэн өгөх, бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэхээс өмнө үнийг нь урьдчилан авсан тохиолдолд урьдчилж орсон орлого дансанд бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас үнэ төлбөргүй өгсөн номын төлбөр болох 5.2 сая төгрөгийг өглөгийн дансанд бүртгэсэн байгаа нь Сангийн сайдын 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 1.4 дүгээр заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай 5.1.4-т “Үнэн зөв байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

3. Урьдчилж төлсөн зардал болох 4.3 сая төгрөгийг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1. “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

4. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, төсөл хөтөлбөрийн зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал зэрэг нийт 35.9 сая төгрөгийн зардлын эдийн засгийн ангиллыг буруу бүртгэсэн нь Сангийн сайдын 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 3.5 дугаар заалт “Төсвийн зардлыг одоогийн мөрдөж байгаа хууль тогтоомж, сангийн яамнаас гаргасан дансны нэгдсэн жагсаалтын дагуу ангилан бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

5. ТӨБЗГ-т түрээсийн орлогын төвлөрүүлэх зардлын илүү шилжүүлсэн төлбөр болох 0.8 сая төгрөгийн авлагыг тайлант үеийн зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “Жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “Үнэн зөв байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

Аудитаар илэрсэн 110.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

2019 онд Боловсролын тухай хуульд өөрчлөлт орж төрийн өмчийн их дээд сургуульд улсын төсвөөс санхүүжилт олгохгүй болсонтой холбогдуулан тэдгээр сургуулийн улсын төсөвт гэсэн статус болон үүнтэй холбогдуулан Нягтлан бодох бүртгэлийн ямар стандартыг мөрдөх болохыг эргэж харж, бодлогын баримт бичигт тодорхойлох нь зүйтэй байна.

СУИС нь улсын төсвөөс санхүүжилт авдаггүй боловч улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн улсын бүртгэлийн гэрчилгээтэй /статустай/ байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр **төсвийн хөрөнгөөр санхүүждэг**, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө” гэж заасан ба тус сургууль УСНББОУС-г мөрдөж байгаа нь Төсвийн тухай хуулийн 4.1.34.“төсвийн байгууллага” гэж **баталсан төсвийн дагуу** төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Соёл урлагийн их сургууль нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 247 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан байна.

Нийт 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Соёл урлагийн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Соёл урлагийн их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. **Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

3.1.1. **Илрүүлэлт:** 2019 оны санхүүгийн тайланд тусгагдсан үндсэн хөрөнгийн дүнд бодит үнэ цэнээр илэрхийлэгдээгүй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үйл ажиллагаанд хэвийн ашиглагдаж байгаа 693 нэр төрлийн 2,850.4 сая төгрөгийн анхны өртөг, хуримтлагдсан элэгдэлтэй, 1723 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2019 онд баталсан “Журам шинэчлэн батлах тухай” 271 дүгээр тогтоолын 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

3.1.2. **Эрсдэл:** Хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

3.1.3 **Өгсөн зөвлөмж:** Хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгэх үйл ажиллагаа зохион байгуулж, ТӨБЗГ-т хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх.

3.1.4 **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

3.2. **Дотоод хяналттай холбоотой асуудал**

3.2.1. **Илрүүлэлт:** Дотоод журамд заасан бэлэн мөнгөний зарцуулалтын лимитээс давсан зарим гүйлгээг удирдлагаар хянуулж баталгаажуулаагүй, зарим бэлэн мөнгөний зарлагын баримтад мөнгө хүлээн авсан хүний гарын үсэг дутуу зэрэг хүчин төгөлдөр бус баримтыг үндэслэн бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, Соёл урлагийн их сургуулийн захирлын 2015 оны 148 тоот тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба горим”-ын 3.8.1-д “Төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх 1 удаагийн дээд хэмжээ нь 500.0 мянган төгрөгөөс хэтрэхгүй байна. Бэлэн мөнгөөр төлбөр гүйцэтгэх 1 удаагийн

дээд хэмжээнээс давсан гадаад, дотоод албан томилолт, гадаад зочны зардал, тэтгэмж, урамшуулал, шагнал, бусад төсөл хөтөлбөр зэрэгт зайлшгүй бэлнээр төлбөр төлөх шаардлагатай тохиолдолд бэлэн мөнгө авах үндэслэлийг тодорхой тусгасан албан хүсэлт, СЭЗГ-ын даргын зөвшөөрлийг үндэслэн гүйцэтгэж болно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл: Хөрөнгийг үргүй, зүй бусаар зарцуулах, бэлэн мөнгөний зарцуулалтад тавих дотоод хяналтыг сулрах;

3.2.3. Өгсөн зөвлөмж: Бэлэн мөнгөний зарлагын гүйлгээнд тавих дотоод хяналтыг сайжруулах, холбогдох хууль, заавар журмыг мөрдөж ажиллах;

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

3.3. Авлагын данстай холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт: Авлагын дансанд 5 ба түүнээс жилийн насжилттай 45.8 сая төгрөгийн авлага үлдэгдэлтэй, эдгээр авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна. Соёл урлагийн их сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт “авлагын насжилт болон нөөц тооцох хувь хэмжээг хамгийн ихдээ 3 жилд нэг удаа хянана”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй”, 71.1.8-д “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” гэж заасантай нийцэхгүй байна.

3.3.2. Эрсдэл: Авлага барагдуулаагүй байх, найдваргүй авлага үүсэх;

3.3.3. Өгсөн зөвлөмж: Олон жил болсон, насжилт өндөртэй авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээ авч анхаарч ажиллах.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

3.4. Хөрөнгөтэй холбоотой асуудал

3.4.1. Илрүүлэлт: 2008 онд бараа материалын дансанд 6 ширхэг ширээ, 21 ширхэг сандал нийт 2.8 сая төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгийг бүртгэсэн байна. Эдгээр хөрөнгийг тайлант онд Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэргүй данснаас хасч, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд бүртгэсэн нь үнэн зөв байх, бодитой байх батламж мэдэгдлийг хангахгүй, ТӨБЗГ-ын 2019 онд баталсан “Журам шинэчлэн батлах тухай” 271 дүгээр тогтоолын 6.1-д Төрийн өмчит хуулийн этгээд нь хагас болон бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтээр цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах саналаа энэ журамд заасан баримт материалын хамт хагас жилд 1 удаа Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

3.4.2. Эрсдэл: Хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн байх, холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх;

3.4.3. Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг зөв ангилан бүртгэж байх, хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасахдаа эрх бүхий байгууллага, удирдлагын тушаал, шийдвэрийг үндэслэж байх.

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

3.5. Хөрөнгөтэй холбоотой асуудал

3.5.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн шинжтэй 55.0 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "Жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-т "Үнэн зөв байх", Сангийн сайдын 388 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4 дүгээр зүйлийн 4.15-д "Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс, худалдах зориулалтаар хадгалагдаж байгаа (улсын нөөцийн бараа зэрэг) бэлэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, үйлдвэрлэлийн процесст байгаа хагас боловсруулсан бүтээгдэхүүн зэрэг болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.5.2. Эрсдэл: Хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хөрөнгө бэлтгэхдээ эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй байх, хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах;

3.5.3. Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг холбогдох хууль, заавар, журмын дагуу бүртгэж байх

3.5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,433,110,695.18	5,605,488,432.13
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,611,817,399.14	3,136,046,731.08
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	3,778,154.83	4,028,387.72
31110	Төгрөг	3,778,154.83	4,028,387.72
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,608,039,244.31	3,132,018,343.36
3121	Төгрөг	3,788,453,188.29	2,191,300,747.77
31213	Арилжааны банк дахь харилцах	3,788,453,188.29	2,191,300,747.77
3122	Гадаад валют	819,586,056.02	940,717,595.59
31223	Арилжааны банк дахь харилцах	819,586,056.02	940,717,595.59
33	АВЛАГА	1,449,879,281.95	1,031,593,759.46
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,190,164,370.62	982,155,635.47
33300	Татаас, санхүүжилтийн авлага	223,543,739.15	-
335	Бусад авлага	35,638,672.19	48,105,623.99
3351	Байгууллагаас авах авлага	33,462,072.30	47,092,948.09
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,176,599.89	1,012,675.90
336	Зээлийн авлага	532,500.00	1,332,500.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	532,500.00	1,332,500.00
33613	Сургалтын төрийн сангийн зээлийн авлага	532,500.00	1,332,500.00
34	УРЬДЧИЛГАА	11,563,540.00	11,686,471.66
34600	Урьдчилж гарсан зардал	11,563,540.00	11,686,471.66
35	БАРАА МАТЕРИАЛ	1,359,850,474.09	1,426,161,469.93
351	Түүхий эд материал	145,978,300.00	167,643,480.00
35110	Тусгай зориулалттай материал	145,978,300.00	167,643,480.00
354	Хангамжийн материал	1,213,872,174.09	1,258,517,989.93
35410	Бичиг хэргийн материал	21,012,999.43	17,239,305.84
35420	Аж ахуйн материал	392,165,313.99	370,962,901.65
35430	Сэлбэг хэрэгсэл	5,816,494.00	5,305,854.00
35440	Түлш, шатах тослох материал	-	130,000.00
35450	Барилгын засварын материал	7,654,900.00	8,477,650.00
35470	Бусад хангамжийн материал	787,222,466.67	856,402,278.44
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11,827,874,712.02	12,087,735,991.66
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,827,874,712.02	12,087,735,991.66
392	Биет хөрөнгө	11,124,079,712.02	11,361,899,325.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,770,839,416.25	9,559,029,281.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	(5,924,563.38)	(384,514,782.30)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	256,638,000.00	256,638,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(187,137,305.62)	(206,228,972.38)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,384,960,359.03	3,405,247,071.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,570,375,717.10)	2,735,442,314.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,310,856,859.00	1,295,874,453.83

Соёл урлагийн их сургуулийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

39208	Хуримтлагдсан элэгдэл	(645,832,771.52)	(619,546,611.11)
39209	Зам, гүүрийн байгууламж	83,996,531.08	85,691,517.08
39210	Хуримтлагдсан элэгдэл	(7,408,168.58)	(15,613,535.27)
39213	Түүх соёл, музейндурсгалт зүйлс	2,718,900.00	2,718,900.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	878,567,249.28	886,589,601.48
39215	Хуримтлагдсан элэгдэл	(750,940,958.86)	(818,285,813.11)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	19,673,314.00	-
39217	Ном	583,448,568.44	649,742,528.67
393	Биет бус хөрөнгө	703,795,000.00	725,836,666.66
39301	Програм хангамж	8,140,000.00	31,140,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(8,140,000.00)	(9,098,333.34)
39303	Бусад биет бус хөрөнгө	703,795,000.00	703,795,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	19,260,985,407.20	17,693,224,423.79
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,044,392,628.33	1,918,335,521.66
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,044,392,628.33	1,918,335,521.66
413	Өглөг	1,960,886,858.33	94,911,583.60
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	874,215.94	507,800.34
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	2,160,000.00
4136	Бусад өглөг	1,960,012,642.39	92,243,783.26
41361	Байгууллагад төлөх өглөг	8,619,067.00	44,121,931.26
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,951,393,575.39	48,121,852.00
414	Урьдчилж орсон орлого	83,505,770.00	1,823,423,938.06
41440	Бусад урьдчилж орсон орлого	83,505,770.00	1,823,423,938.06
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,216,592,778.87	15,774,888,902.13
51	Засгийн газрын хувь оролцоо	17,216,592,778.87	15,774,888,902.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,872,800,270.44	4,872,800,270.44
51101	Өмч:- төрийн	4,872,800,270.44	4,872,800,270.44
512	Хуримтлагдсан үр дүн	6,714,267,097.11	5,273,515,234.37
51210	Өмнөх үеийн үр дүн	7,070,922,804.46	6,491,053,371.96
51220	Тайлант үеийн үр дүн	(356,655,707.35)	(1,217,538,137.59)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,629,525,411.32	5,628,573,397.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	19,260,985,407.20	17,693,224,423.79

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,185,165,222.94	9,881,509,442.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,185,165,222.94	9,881,509,442.72
120	Нийтлэг татварын бус орлого	10,185,165,222.94	9,881,509,442.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,173,543,334.86	8,732,188,332.72
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,053,315,219.33	7,816,510,490.30
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	980,257,022.53	837,581,987.42
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	139,971,093.00	78,095,855.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,011,621,888.08	1,149,321,110.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	884,830,888.08	1,022,530,110.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	236,862,626.08	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	647,968,262.00	1,022,530,110.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,599,386,677.29	11,126,305,394.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,599,386,677.29	11,126,305,394.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,485,390,848.29	11,034,357,870.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,397,585,222.17	6,408,562,947.01
210101	Үндсэн цалин	6,044,251,459.31	5,945,429,885.25
210105	Гэрээт ажлын хөлс	353,333,762.86	463,133,061.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	763,228,588.44	809,983,120.07
210201	Тэтгэврийн даатгал	525,672,329.32	569,164,613.66
210202	Тэтгэмжийн даатгал	63,411,219.44	67,076,311.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	54,097,684.46	53,102,970.73
210204	Ажилгүйдлийн даатгал	9,884,754.81	9,763,942.20
210205	Эрүүл мэндийн даатгал	110,162,600.41	110,875,281.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	237,002,325.08	240,999,565.48
210301	Гэрэл, цахилгаан	111,018,900.30	107,232,720.04
210302	Түлш, халаалт	83,347,539.06	85,797,011.40
210303	Цэвэр, бохир ус	42,635,885.72	38,576,049.89
210304	Байрны түрээс	-	9,393,784.15
2104	Хангамж, бараа материалын зардал	412,913,242.54	413,281,590.51
210401	Бичиг хэрэг	47,259,490.66	61,180,342.26
210402	Тээвэр, шатахуун	32,821,996.95	24,833,669.78
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	72,072,724.42	65,781,979.43
210404	Ном, хэвлэл	82,807,267.96	88,011,014.86
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	116,740,803.46	112,054,730.47
210408	Бараа материал акталсны зардал	61,210,959.09	61,419,853.71
2105	Нормативт зардал	-	1,697,995.00
210502	Хоол, хүнс	-	1,697,995.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	399,361,270.11	614,105,346.00
210604	Урсгал засвар	399,361,270.11	614,105,346.00
2107	Томилолт, зочны зардал	267,481,949.26	306,162,494.23
210701	Гадаад албан томилолт	202,594,333.22	268,244,920.26
210702	Дотоод албан томилолт	11,979,013.50	12,295,150.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	52,908,602.54	25,622,423.97
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	166,456,434.29	130,174,568.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	166,456,434.29	130,174,568.42
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,841,361,816.41	2,109,390,243.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	774,530,822.55	685,738,474.45
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	325,845,633.27	505,410,489.59
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	740,985,360.59	918,241,279.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,995,829.00	91,947,524.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	113,995,829.00	91,947,524.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	113,995,829.00	91,947,524.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(414,221,454.35)	(1,244,795,952.15)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	138,671,810.96	63,203,572.38
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	104,823,560.96	63,203,572.38
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	33,848,250.00	
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	81,106,063.96	35,945,757.82
225002	Найдваргүй авлагын алдагдал	8,095,994.50	
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	45,347,160.40	35,945,757.82
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	27,662,909.06	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	57,565,747.00	27,257,814.56
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(356,655,707.35)	(1,217,538,137.59)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>9,778,562,147.28</u>	<u>9,814,463,246.56</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,913,002,885.28	8,665,893,087.56
120	Нийтлэг татварын бус орлого	8,913,002,885.28	8,665,893,087.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,913,002,885.28	8,665,893,087.56
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,912,761,097.04	7,843,750,638.04
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,241,788.24	822,142,449.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	865,559,262.00	1,148,570,159.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	738,768,262.00	1,021,779,159.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	90,000,000.00	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	648,768,262.00	1,021,779,159.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>9,951,095,922.74</u>	<u>10,215,322,889.82</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,951,095,922.74	10,215,322,889.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,835,850,852.14	10,122,379,484.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,318,591,455.49	6,406,429,738.01
210101	Үндсэн цалин	6,019,376,015.68	5,938,220,516.93
210105	Гэрээт ажлын хөлс	299,215,439.81	468,209,221.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	759,427,811.15	808,824,833.21
210201	Тэтгэврийн даатгал	524,923,517.98	569,018,980.05
210202	Тэтгэмжийн даатгал	63,364,007.16	66,823,148.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	52,430,782.48	52,900,440.02
210204	Ажилгүйдлийн даатгал	9,868,551.78	9,713,309.70
210205	Эрүүл мэндийн даатгал	108,840,951.75	110,368,954.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	237,002,325.08	239,685,949.08
210301	Гэрэл, цахилгаан	108,295,287.20	105,039,103.64
210302	Түлш, халаалт	86,071,152.16	85,797,011.40
210303	Цэвэр, бохир ус	42,635,885.72	38,512,049.89
210304	Байрны түрээс		10,337,784.15
2104	Хангамж, бараа материалын зардал	446,054,033.24	370,687,372.52
210401	Бичиг хэрэг	47,915,980.92	50,571,251.00
210402	Тээвэр, шатахуун	32,472,234.00	26,875,210.78
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	73,029,064.42	64,844,679.43
210404	Ном, хэвлэл	168,945,131.90	105,858,715.86
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	123,691,622.00	122,537,515.45
2105	Нормативт зардал	-	1,697,995.00
210502	Хоол, хүнс	-	1,697,995.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	479,081,133.90	641,889,752.69
210604	Урсгал засвар	479,081,133.90	641,889,752.69
2107	Томилолт, зочны зардал	279,708,868.09	301,069,518.00
210701	Гадаад албан томилолт	221,150,353.39	268,975,848.70
210702	Дотоод албан томилолт	10,616,416.50	10,042,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	47,942,098.20	22,051,169.30

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	165,216,832.33	129,004,121.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	165,216,832.33	129,004,121.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,150,768,392.86	1,223,090,203.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	767,436,600.31	710,542,848.94
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	383,331,792.55	512,547,354.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,245,070.60	92,943,405.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	115,245,070.60	92,943,405.81
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	115,245,070.60	92,943,405.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(172,533,775.46)</u>	<u>(400,859,643.26)</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>(547,604,884.70)</u>	<u>(1,109,672,758.05)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	547,604,884.70	1,109,672,758.05
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	547,604,884.70	1,109,672,758.05
2200	Дотоод эх үүсвэрээр	547,604,884.70	1,109,672,758.05
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	547,604,884.70	1,109,672,758.05
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(547,604,884.70)</u>	<u>(1,109,672,758.05)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>97,402,314.84</u>	<u>34,761,733.25</u>
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	<u>(97,402,314.84)</u>	<u>(34,761,733.25)</u>
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	(97,402,314.84)	(34,761,733.25)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>97,402,314.84</u>	<u>34,761,733.25</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	<u>(622,736,345.32)</u>	<u>(1,475,770,668.06)</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,234,553,744.46	4,611,817,399.14
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,611,817,399.14	3,136,046,731.08

4.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,209,405,270.44	928,522,406.33	7,056,740,739.34	12,194,668,416.11
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		4,701,003,004.99	14,182,065.12	4,715,185,070.11
Тайлант үеийн үр дүн	663,395,000.00		(356,655,707.35)	306,739,292.65
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,872,800,270.44	5,629,525,411.32	6,714,267,097.11	17,216,592,778.87
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(223,213,725.15)	(223,213,725.15)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,872,800,270.44	5,629,525,411.32	6,491,053,371.96	16,993,379,053.72
Тайлант үеийн үр дүн		(952,014.00)	(1,217,538,137.59)	(1,218,490,151.59)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,872,800,270.44	5,628,573,397.32	5,273,515,234.37	15,774,888,902.13

4.5 Аудит хийсэн төлөвлөгөө гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны		Дүн	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,782,069,210.48	11,324,995,647.87	3,457,073,562.61	76.6
УРСГАЛ ЗАРДАЛ	13,460,261,350.48	10,336,596,409.82	3,123,664,940.66	76.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,284,741,180.48	10,243,653,004.01	3,041,088,176.47	77.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,825,387,500.13	6,406,429,738.01	1,418,957,762.12	81.9
Үндсэн цалин	7,063,578,974.00	5,938,220,516.93	1,125,358,457.07	84.1
Гэрээт ажлын хөлс	761,808,526.13	468,209,221.08	293,599,305.05	61.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	987,254,529.25	808,824,833.21	178,429,696.04	81.9
Тэтгэврийн даатгал	671,333,080.51	569,018,980.05	102,314,100.46	84.8
Тэтгэмжийн даатгал	78,980,417.58	66,823,148.53	12,157,269.05	84.6
ҮОМШӨ-ний даатгал	63,184,290.44	52,900,440.02	10,283,850.42	83.7
Ажилгүйдлийн даатгал	15,796,072.40	9,713,309.70	6,082,762.70	61.5
Эрүүл мэндийн даатгал	157,960,668.32	110,368,954.91	47,591,713.41	69.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	346,913,543.22	239,685,949.08	107,227,594.14	69.1
Гэрэл, цахилгаан	136,339,253.77	105,039,103.64	31,300,150.13	77.0
Түлш, халаалт	130,495,780.80	85,797,011.40	44,698,769.40	65.7
Цэвэр, бохир ус	80,078,508.65	38,512,049.89	41,566,458.76	48.1
Байрны түрээс		10,337,784.15	(10,337,784.15)	
Хангамж, бараа материалын зардал	527,123,318.00	370,687,372.52	156,435,945.48	70.3
Бичиг хэрэг	64,556,640.00	50,571,251.00	13,985,389.00	78.3
Тээвэр, шатахуун	46,130,988.00	26,875,210.78	19,255,777.22	58.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	81,241,520.00	64,844,679.43	16,396,840.57	79.8
Ном, хэвлэл	193,547,110.00	105,858,715.86	87,688,394.14	54.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	58,557,800.00	49,427,835.85	9,129,964.15	84.4
Аж ахуйн материал худалдан авах зардал	83,089,260.00	73,109,679.60	9,979,580.40	88.0
Нормативт зардал	-	1,697,995.00	(1,697,995.00)	
Хоол, хүнс		1,697,995.00	(1,697,995.00)	
Эд хогшил, урсгал засварын зардал	891,559,256.55	763,163,272.69	128,395,983.86	85.6
Тавилга	162,688,700.00	121,273,520.00	41,415,180.00	74.5
Урсгал засвар	728,870,556.55	641,889,752.69	86,980,803.86	88.1
Томилолт, зочны зардал	522,804,052.99	301,069,518.00	221,734,534.99	57.6
Гадаад албан томилолт	386,647,077.50	268,975,848.70	117,671,228.80	69.6
Дотоод албан томилолт	51,475,847.99	10,042,500.00	41,433,347.99	19.5
Зочин төлөөлөгч хүлээн авах	84,681,127.50	22,051,169.30	62,629,958.20	26.0

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	287,447,771.34	129,004,121.63	158,443,649.71	44.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	287,447,771.34	129,004,121.63	158,443,649.71	44.9
Бараа үйлчилгээний бусад зардал	1,896,251,209.00	1,223,090,203.88	673,161,005.12	64.5
Бараа үйлчилгээний бусад зардал	1,205,081,609.00	711,642,848.94	493,438,760.06	59.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	691,169,600.00	511,447,354.94	179,722,245.06	74.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	175,520,170.00	92,943,405.81	82,576,764.19	53.0
Бусад урсгал шилжүүлэг	175,520,170.00	92,943,405.81	82,576,764.19	53.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	175,520,170.00	92,943,405.81	82,576,764.19	53.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,321,807,860.00	988,399,238.05	333,408,621.95	74.8
Дотоод эх үүсвэрээр	1,321,807,860.00	988,399,238.05	333,408,621.95	74.8
Барилга байгууламж	930,000,000.00	731,602,534.80	198,397,465.20	78.7
Тоног төхөөрөмж	239,770,080.00	167,670,888.02	72,099,191.98	69.9
Бусад хөрөнгө	152,037,780.00	89,125,815.23	62,911,964.77	58.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,769,656,907.87	9,814,463,246.56	955,193,661.31	91.1
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	424,342,543.22	1,021,779,159.00	(597,436,615.78)	240.8
Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	77,429,000.00	1,021,779,159.00	(944,350,159.00)	1,319.6
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	132,808,200.00	126,791,000.00	6,017,200.00	95.5
Орон нутгийн төсвөөс	132,808,200.00	126,791,000.00	6,017,200.00	95.5
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,212,506,164.65	8,665,893,087.56	1,546,613,077.09	84.9
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,278,669,004.50	7,843,750,638.04	1,434,918,366.46	84.5
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	933,837,160.15	822,142,449.52	111,694,710.63	88.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,611,817,399.14		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,136,046,731.08		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019/12/31	Аудитын нэр: Соёл урлагийн их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код: САГ-2020/82/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: Соёл урлагийн их сургууль	сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Авлагын дансанд 5 ба түүнээс жилийн насжилттай 45.8 сая төгрөгийн авлага үлдэгдэлтэй, эдгээр авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна.	45.8	Зөвлөмж өгөх	Захирал, СЭЗГ-ын дарга	Э.Сонинтогос Ж.Жагармаа
2	Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалаар бүртгэсэн	55.0	Зөвлөмж өгөх	Захирал, СЭЗГ-ын дарга	Э.Сонинтогос Ж.Жагармаа
3	Бараа материалд бүртгэлтэй байсан 2.8 сая төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгийн шинж чанартай 6 ширхэг никель хөлтэй ширээ болон 21 ширхэг сандлыг тайлант хугацаанд данснаас хасч хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд бүртгэсэн	2.8	Зөвлөмж өгөх	Захирал, СЭЗГ-ын дарга	Э.Сонинтогос Ж.Жагармаа
4	2019 оны санхүүгийн байдлын тайланд тусгагдсан үндсэн хөрөнгийн дүнд бодит үнэ цэнээр илэрхийлэгдээгүй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үйл ажиллагаанд хэвийн ашиглагдаж байгаа 693 нэр төрлийн 2,850.4 сая төгрөгийн анхны өртөг, хуримтлагдсан элэгдэлтэй, 1723 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал, СЭЗГ-ын дарга	Э.Сонинтогос Ж.Жагармаа
5	Дотоод журамд заасан бэлэн мөнгөний зарцуулалтын лимитээс давсан зарим гүйлгээг удирдлагаар хянуулж баталгаажуулаагүй, зарим бэлэн мөнгөний зарлагын баримтад мөнгө хүлээн авсан хүний гарын үсэг дутуу зэрэг хүчин төгөлдөр бус баримтыг үндэслэн бүртгэлд тусгасан байна.	6.5	Зөвлөмж өгөх	Захирал, СЭЗГ-ын дарга	Э.Сонинтогос Ж.Жагармаа
	Дүн	110.2			